

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2024 оны 02 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Гадаад эдийн засаг – БНХАУ, ОХУ



ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ-ий өсөлт

(2023 он)

7.0 хувь

Валютын нөөц

(2024 оны 3 дугаар сарын 15)

5,016 сая \$

Инфляц

(2024 оны 2 дугаар сар)

7.0 хувь

Төсвийн тэнцэл

(2024 оны 2 дугаар сар)

1.3 их наяд ₮

Экспорт

(2024 оны 2 дугаар сар)

2,240 сая \$

Импорт

(2024 оны 2 дугаар сар)

1,596 сая \$

ГШХО

(2023 он)

3.1 тэрбум \$

Зээлийн хүү

(2023 оны 2 дугаар сар)

17.0 хувь

Ажилчдын тоо

(2023 оны 4 дүгээр улирал)

1.2 сая

*V улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 58 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2023 оны 4 дүгээр улирал)

16.4 хувь

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2023 оны эцэс)

96.8 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2023 оны 4 дүгээр улирал)


14.1 хувь



Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2024 оны 2 дугаар сард өмнөх оноос 12 хувиар өслөө. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл гол нөлөөг үзүүлсэн хэвээр байна.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ


(тэрбум төгрөг)



- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2024 оны 2 дугаар сард 4.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 12 хувиар өслөө.
- Нүүрс, зэсийн баяжмал, алт, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл 13 хувиар нэмэгдээд байна.
- Боловсруулах салбарын гарц 9 хувиар, цахилгаан болон усан хангамжийн салбарын үйлдвэрлэл тус тус 12, 23 хувиар өсөөд байна.

БОДИТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(еселтийн хувь)



- Аж үйлдвэрийн салбарын бодит үйлдвэрлэл 2024 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар өсөөд байна.
- Үүний 6.2 нэгж хувийг уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн өсөлт бүрдүүлж байна.

УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ


(голлох бүтээгдэхүүнээр)

Өмнөх оноос өөрчлөлт:	Өмнөх оноос өөрчлөлт:
Нүүрс	13.7 сая тонн 20%
Зэсийн баяжмал	232 мян.тонн 4%
Газрын тос	0.7 сая баррель -11%
Алт	1.2 тонн 2%
Төмрийн хүдэр	697 мянган тонн 15%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Нүүрс олборлолт 2024 оны 2 дугаар сард 13.7 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 20 хувиар нэмэгдлээ.
- Зэсийн баяжмал үйлдвэрлэл өмнөх оны эхний 2 сараас 4 хувиар, алт олборлолт 2 хувиар нэмэгдэв.
- Төмрийн хүдэр, баяжмал олборлолт өмнөх оны мөн үеэс 15 хувиар нэмэгдээд байна.
- Харин газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшинг даваагүй байна.

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100)




- Үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 0.3 хувь, цар тахлын өмнөх үеэс 65 хувиар тус тус өслөө. Үнийн индексийг салбараар харвал:
- Хүнсний бүтээгдэхүүн 15.7 хувиар,
- Ундаа, согууруулах ундаа 7.7 хувиар,
- Нэхмэлийн үйлдвэрлэлийнх 7.9 хувиар тус тус өссөн бол
- Уул уурхай, олборлолтын үйлдвэрлэл 1.1 хувиар,
- Арьс, арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийнх 0.4 хувиар тус тус буурлаа.



Гадаад, дотоод эрэлт эерэг төлөвтэй байж, эдийн засаг өсөлтөө хадгаллаа.


ДНБ ӨСӨЛТИЙН БҮТЭЦ

(жилийн өсөлтийн хувь)



ЭЦСИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ БҮТЭЦ

(жилийн өсөлтийн хувь)



ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН БҮТЭЦ

(жилийн өсөлтийн хувь)



ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(жилийн өсөлтийн хувь)



- Эрэлтээс тооцсон ДНБ 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 7.1 хувиар өслөө.
- Өсөлтөд эцсийн хэрэглээ 6.1 нэгж хувийн, цэвэр экспорт 5.2 нэгж хувийн тус тус эерэг нөлөө, хөрөнгийн хуримтлал -4.3 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүллээ.

- Эцсийн хэрэглээ 2023 онд 25.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.2 хувиар өсөв.
- Эцсийн хэрэглээний өсөлтийн 5.7 нэгж хувийг өрхийн хэрэглээ, 1.6 нэгж хувийг төрийн хэрэглээ бүрдүүлж байна.


- Үндсэн хөрөнгийн хуримтлал 7.0 хувиар өслөө.
- Үндсэн хөрөнгийн хуримтлалын өсөлтөд орон сууцны бус барилга байгууламж 6.4 нэгж хувийн, машин тоног төхөөрөмж 2.7 нэгж хувийн, орон сууцны барилга 0.6 нэгж хувийн нэмэгдүүлэх нөлөөг тус тус үзүүлсэн бол том малын хорогдол 2.4 нэгж хувийн бууруулах нөлөө үзүүллээ.

- Бараа, үйлчилгээний экспорт 2023 онд импортоос 2 дахин хурдтай нэмэгдлээ.
- Бараа, үйлчилгээний цэвэр экспорт -7.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 16.6 хувиар буурав.




2024 оны эхний 2 сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл 644 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 38 хувиар буурлаа.

ЭКСПОРТ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- 2024 оны 2 дүгээр сарын байдлаар экспорт 2,240 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 4 сая ам доллароор буурлаа.
- Нийт экспортын 95 хувийг уул уурхай бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспорт дангаараа 60 хувийг бүрдүүлж байна.

- Нүүрсний экспортын орлого 1,336 сая ам долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5 хувиар өслөө.
- Эзсийн баяжмалын экспортын орлого 445 сая ам долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 90 сая ам долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 28 хувиар өслөө.
- Газрын тосны экспортын орлого 54 сая ам долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6 хувиар буурлаа.

- 2024 оны 2 дугаар сарын байдлаар импорт 1,596 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 33 хувиар өссөн байна.
- Нийт импортын 20 хувийг нефт, 17 хувийг тоног төхөөрөмж, 11 хувийг автомашин эзэлж байна.


- Тоног төхөөрөмжийн импорт 328 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 39 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 182 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 2 дахин өслөө.
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 327 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн 32 хувиар өслөө.



2024 оны эхний 2 сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 95 хувийг, тэр дундаа нүүрс болон зэсийн баяжмал дангаараа 80 хувийг бүрдүүллээ.

НҮҮРС


(сая тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЗЭСИЙН БАЯМЖАЛ


(тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ТӨМРИЙН ХҮДЭР


(мян. тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГАЗРЫН ТОС

(мян. баррель)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспорт 2024 оны 2 дугаар сард 4.0 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 7 хувиар буурлаа.
- Гашуунсухайт боомтоор 3.6 сая тонн, Шивээхүрэн боомтоор 1.8 сая тонн, Ханги боомтоор 0.6 сая тонн, бусад боомтуудаар 0.7 сая тонн нүүрс экспортолсон байна.

- Зэсийн баяжмалын экспорт 2024 оны 2 дугаар сард 129 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 17 хувиар өслөө.
- Гашуунсухайт боомтоор 73 мянган тонн, Зам-үүд боомтоор 51 мянган тонн зэсийн баяжмал экспортолсон байна.


- Төмрийн хүдрийн экспорт 2024 оны 2 дугаар сард 525 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 11 хувиар өслөө.
- Зам-үүд боомтоор 525 мянган тонн, Бургастай боомтоор 63 мянган тонн, бусад боомтуудаар 8 мянган тонн төмрийн хүдэр экспортолсон байна.

- Газрын тосны экспорт 2024 оны 2 дугаар сард 357 мянган баррельд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 5 хувиар буурлаа.
- Баянхошуу боомтоор 340 мянган баррель, Замын-үүд боомтоор 17 мянган баррель газрын тос тус тус экспортолсон байна.




2024 оны эхний 2 сард сарын ноос, ноолуураас бусад голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.

МАЛЫН МАХ (тонн)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

БОЛОВСРУУЛСАН АРЬС ШИР (мянган дм квадрат)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООЛУУР (тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООС (тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Малын махны экспорт 2024 оны эхний 2 сард 9,314 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 48 хувиар буурлаа.
- Тэр дундаа боловсруулсан махны экспорт өмнөх оны мөн үеэс 3 дахин багасаж 2,785 мянган тоннд хүрлээ.

- Боловсруулсан арьс ширний экспорт 2024 оны эхний 1 сард 5,651 мянган дм квадратад хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 41 хувиар буурлаа.

- Ноолуурын экспорт 2024 оны эхний 2 сард 162 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 60 хувиар өслөө.


- Ноосны экспорт 2024 оны эхний 1 сард 28 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 10 хувиар өслөө.



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС

(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)




Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2024 оны эхний 2 сарын дундаж үнэ 315 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16 хувиар буурсан байна.

ЗЭС

(\$/тонн, Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)



Эх сурвалж: Блүүмберг

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2024 оны эхний 2 сарын дундажар 8,311 ам.доллар болж, өмнөх оны мөн 8 хувиар буурсан байна.

ТӨМРИЙН БАЯЖМАЛ

(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламттай төмрийн баяжмал)




Эх сурвалж: Блүүмберг

- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2024 оны эхний 2 сарын дундаж үнэ 125 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 1 хувиар буурсан байна.

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Brent)



Эх сурвалж: Блүүмберг


- Бrent газрын тосны 2024 оны эхний 2 сарын дундаж үнэ 80 ам.долларт хүрч өмнөх оны эцсээс 4 хувиар өслөө.



2024 оны 2 дугаар сарын байдлаар УУББ-ээр 9 төрлийн, нийт 20 сая тонн нүүрс, 1,023 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг арилжаалаад байна.

НҮҮРСНИЙ АРИЛЖАА


(сая тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ


(ам.доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТӨМРИЙН АРИЛЖАА


(мянган тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТӨМРИЙН ДУНДАЖ ҮНЭ

(ам.доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2024 оны 2 дугаар сарын байдлаар нийт 20 сая тонн нүүрс арилжиж, 2.8 тэрбум ам.долларын орлого олжээ.
- 2024 оны 2 дугаар сарын байдлаар 2024 онд 5.1 сая тонн нүүрс арилжиж, 691 сая ам.долларын орлого олжээ.
- 2024 оны 1 дүгээр сард 1.5 сая тонн нүүрс борлуулсан бол 2 дугаар сард 2.4 сая тонн нүүрс борлууллаа.

- Нүүрсний 2 дугаар сард дуудах дундаж үнэ 157 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 178 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 2 дугаар сард хэлцлийн доод үнэ 79 ам.доллар, дээд үнэ 206 ам.долларт хүрсэн ба дундаж үнэ 178 ам.доллар байна.


- 2023 оны 9 дүгээр сараас хойш 2023 онд нийт 677.5 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 196 тэрбум төгрөг буюу 57 сая ам.долларын борлууллаа.
- 2024 оны 2 дугаар сарын байдлаар 303 мянган тонн төмрийг арилжаалж, 24 сая ам.долларын орлого олжээ.
- 2024 оны 2 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК биржээр төмрийн хүдэр арилжаалж эхэлсэн.

- Төмрийн хүдэр болон баяжмалын 2 дугаар сарын дуудах дундаж үнэ 74 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 77 ам.доллар хүрч буураа.
- Төмрийн төрлөөс хамааран 2 дугаар сард хэлцлийн доод үнэ 56 ам.доллар, дээд үнэ 105 ам.долларт хүрсэн ба дундаж үнэ 77 ам.доллар байна.



Төлбөрийн тэнцэл 2024 оны 1 дүгээр сард 86 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 5 тэрбум ам.долларыг давсан бол төгрөгийн ам.доллартой харьцах ханш чангарсан хэвээр байна.


ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ (сая ам.доллар)



- Төлбөрийн тэнцэл 2024 оны 1 дүгээр сард 86 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 275 сая ам.доллороор муудлаа.
- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 201 сая ам.доллороор нэмэгдсэн бол импорт мөн 272 сая ам.доллороор нэмэгдсэнээр урсгал дансны ашиг өмнөх оны мөн үеэс буурлаа.
- Төлбөрийн тэнцлийн шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал* 2024 оны 1 дүгээр сард 267 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 158 сая ам.доллороор өссөн байна.


*Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон эзэлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгалыг хассан дүн

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ (сая ам.доллар)



- Гадаад валютын улсын нөөц 2024 оны 2 дугаар сарын эцсийн байдлаар 4,971 сая ам.доллар, 3 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 5,016 сая ам.доллар болж, 5 тэрбум ам.долларыг давлаа.
- Энэ нь сүүлийн 12 сарын дунджаар тооцсон барааны импортын 6.3 сарын хэрэгцээг хангах түвшин.

ХАНШИЙН ӨДРИЙН ӨӨРЧЛӨЛТ (төгрөг/ам.доллар)



- 2024 оны 2 дугаар сард төгрөгийн ам.доллартой харьцах ханш өдөрт дунджаар 1.0 төгрөгөөр чангарлаа.
- 2024 оны 2 дугаар сарын эцэст төгрөгийн ам.доллартой харьцах ханш 3,382 болж, оны эхнээс 19.6 төгрөгөөр буюу 0.6 хувиар чангарлаа.

ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА (сая ам.доллар)




- Төв банк 2024 оны 2 дугаар сард нийт 325 сая ам.долларыг банкуудад дуудлага худалдаагаар худалдлаа.
- Энэ нь 2023 оны мөн үеэс 15 сая ам.доллар буюу 5 хувиар их, 2022 оны мөн үеэс 168 сая ам.доллар буюу 34 хувиар бага дүн байв.



Инфляц 2024 оны 2 дугаар сард 7.0 хувь гарч, төв банкны зорилтот түвшинд хадгалагдлаа. Гадаад валютын албан нөөц өсөж, төгрөгийн ханш тогтворжин, тээврийн саатал арилснаар импортын гаралтай инфляц саарч байна. Дотоодын бараа, үйлчилгээний инфляц сүүлийн 5 сар буурч байгаа боловч нийт инфляцад эзлэх нэгж хувь өндөр хэвээр байна. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.7 хувиар өсжээ.

ЖИЛИЙН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

САРЫН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

СУУРЬ ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Инфляц 2024 оны 2 дугаар сард улсын хэмжээнд 7.0 хувьд хүрч, төв банкны зорилтот түвшинд хадгалагдаж байна.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.2 нэгж хувь (31.4%)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 4.8 нэгж хувь буюу 68.6 хувийг эзэлж байна.

- 2024 оны 2 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.7 хувиар өсөв.
- Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас өсөхөд хүнсний бүлэг 73 хувиар нөлөөлжээ.
- Сарын инфляцад мах, махан бүтээгдэхүүн 47%, сүү 6%, талх, гурил, будаа 11%-ийг тус тус бүрдүүлж байна.

- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2024 оны 2 дугаар сард суурь инфляц 6.1 хувь гарч, нийт инфляцын 4.1 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн 6 сар дарааллан буурч байна.

- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 2024 оны 2 дугаар сард жилийн инфляцын 27 хувийг бүрдүүлж байна.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 17.3 хувиар өсжээ.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар өсөв.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 15.8 хувиар өслөө.



Монгол Улсын нэгдсэн төсөв 2024 оны 2 дугаар сарын байдлаар 1.3 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн орлого нэмэгдэхэд уул уурхайн салбараас орж ирэх АМНАТ-ийн орлого өссөн нь голлон нөлөөллөө.

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ


(их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ТӨСВИЙН ОРЛОГО


(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

2024 ОНД НЭМЭГДСЭН ГОЛЛОХ ЗАРЛАГУУД


(зарлагын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(их наяд төгрөг, ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсөв 2024 оны 2 дугаар сард 1.34 тэрбум төгрөгийн ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 1.32 их наяд төгрөгөөр өссөн байна.

Орлого 2024 оны 2 дугаар сард 5.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 2.4 их наяд төгрөг буюу 78 хувиар нэмэгдсэн байна.

Дээрх өсөлтөд орлогын албан татвар 1.1 их наяд төгрөг, АМНАТ 355 тэрбум төгрөг, НӨАТ 261 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голчлон нөлөөллөө.

Зарлага 2024 оны 2 дугаар сард 3.8 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оноос 995 тэрбум төгрөг буюу 36 хувиар нэмэгдсэн байна.

2024 онд төрийн бүх албан хаагчдын цалинг 10 хувиар, нийтлэг үйлчилгээний ажиллагсдын цалинг 20 хувиар, алслагдсан аймаг, сумд дүүргийн төрийн албан хаагчдын цалин 20-40 хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн.


Засгийн газрын өр 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 30.8 их наяд төгрөгт хүрч, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа 43.7 хувьд хүрээд байна.

2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр Засгийн газрын өр (ӨҮЦ)-ийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.



Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт өмнөх сараас 1.8 нэгж хувиар буурлаа. Өмнөх сартай харьцуулахад гадаад валютын харилцах, хадгаламж буурч, төгрөгийн харилцах, хадгаламж нэмэгдсэн байна. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт өмнөх сараас нэмэгдлээ.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХҮҮГИЙН ТҮВШИН (жигнэсэн дундаж хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 2 дугаар эцэст 37.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 24.3 хувиар өссөн байна. Төгрөгийн харилцах, хадгаламж нийт өсөлтийн 25.1 нэгж хувийг, гадаад валютын харилцах, хадгаламж нийт өсөлтийн -0.8 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.

- Нийт хадгаламж 22.5 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 20.0 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 17.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 35.9 хувиар, өмнөх сараас 2.8 хувиар тус тус өслөө.
- Гадаад валютын хадгаламж 4.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.6 хувиар, өмнөх сараас 1.1 хувиар тус тус буурлаа.

- Банкнүүдын зээлийн үлдэгдэл 2024 оны 2 дугаар сарын эцэст 27.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 24.2 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 7.3 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.7 нэгж хувиар буурсан байна.

- Банкнүүдын зээлийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 2 дугаар сард 17.0 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар өсөв.
- Банкнүүдын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 2 дугаар сард 11.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар өслөө.



Эдийн засаг сүүлийн 6 улирал дараалан эерэг өсөлттэй байгаа ч хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлт цар тахлын өмнөх түвшнээс бага хэвээр байна. Мөн сүүлийн 5 улирал дараалан ажиллах хүч буурч, ажиллах хүчнээс гадуурх хүн ам тэлсэн байна.


АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН (хувь)




АЖИЛЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ (мянган хүн)



ДУНДАЖ ЦАЛИНГИЙН ӨӨРЧЛӨЛТ (хувь)



НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ААНБ-ЫН ТОО (мянга, үйл ажиллагаа эрхлэлтэй)



- Ажиллах хүчний оролцооны түвшин 57.6 хувь болж буурсан ба цар тахлын өмнөх үеэс 2.5 хувиар доогуур байна.
- Ажилгүй иргэдийн тоо 2023 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 15.8 мянган хүнээр буурч, 48.8 мянгад хүрлээ.
- Ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буурч, 3.9 хувьд хүрлээ.

- Ажилчдын тоо 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар 1.2 саяд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40 мянган хүнээр нэмэгдсэн ч өсөлтийн хурд бага байна.
- Ажилчдын тооны өсөлтөд, худалдаа, барилга, боловсруулах, тээвэр, үйлчилгээ ба бусад, уул уурхай, ус, цахилгааны салбарын ажилчид эергээр нөлөөлсөн.
- Харин хөдөө аж ахуйн салбарын ажилчид сөргөөр нөлөөллөө.


- Дундаж цалингийн хэмжээ 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 27.7 хувиар өсөж, 2,235 мянган төгрөгт хүрлээ.
- Салбараар авч үзвэл, уул уурхайн салбарын дундаж цалин бусад салбараа тэргүүлж, улсын дунджаас 2.3 дахин өндөр байна.

- Нийт бүртгэлтэй ААНБ-ын тоо өмнөх онтой харьцуулахад буурсан. Үүнд, үйл ажиллагаа явуулаагүй ААНБ буурсан нь голлон нөлөөлжээ.
- Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо 2023 онд 96.8 мянгад хүрч өмнөх оноос 5 мянгаар нэмэгдлээ.
- Уг өсөлтөд худалдаа, үйлчилгээний салбарын жижиг бизнесүүд /1-9 ажилтантай ААН/ийн тоо нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.



2024 оны эхний 2 сард БНХАУ-ын гадаад худалдаа, инфляц, аж үйлдвэрлэл, жижиглэн худалдааны үзүүлэлтүүд өсөлттэй гарлаа. Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2024 оны 2 дугаар сард өмнөх сараас буурч, босго утга 50-аас бага хэвээр байна.


ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI) (нэгж)



- Аж үйлдвэрийн салбарын PMI индекс 2024 оны 2 дугаар сард 49.1 болж, өмнөх сараас 0.1 нэгжээр буурч, сүүлийн 5 сар босго утга 50-аас бага хэвээр байна.
- Аж үйлдвэрийн бус салбарын PMI индекс 50-аас дээш хэвээр байна.


Тус индекс нь богино хугацааны идэвхжлийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүхий эдийн нөөц зэрэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ (хувь, өссөн дүнгээр)



- 2024 оны эхний 2 сард экспорт 7.1 хувиар, импорт 3.5 хувиар тус тус өсөж, шинжээчдийн хүлээлтээс давлаа.

ИНФЛЯЦ (хувь)



- Хэрэглээний үнийн индекс 2024 оны 2 дугаар сард сүүлийн 6 сард анх удаа өсөж, инфляц 0.7 хувьтай гарлаа.

АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ ӨСӨЛТ (хувь)



- Аж үйлдвэрийн гарцын жилийн өсөлт 2024 оны эхний 2 сард 7.0 хувьд хүрсэн нь сүүлийн 2 жилийн хамгийн өндөр өсөлт болов.
- Жижиглэн худалдааны жилийн өсөлт 5.5 хувьд хүрлээ.




ОХУ-ын ДНБ 2023 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өссөн бол 2024 оны 1 дүгээр улиралд 3.7 орчим хувиар өснө гэсэн таамаглалтай байна. Өсөлтийг төсвийн зарлагын тэлэлт, аж үйлдвэрийн өргөжилт, цэрэг армийн зардал дэмжсэн байна.

БОДИТ ДНБ-ИЙ ӨСӨЛТ
(хувь)




Эх сурвалж: Блүүмберг

ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ
(тэрбум ам.доллар)




Эх сурвалж: ОХУ-ын Төв банк

ИНФЛЯЦ
(хувь)



Эх сурвалж: Блүүмберг

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI) (нэгж)



Эх сурвалж: Блүүмберг

- Дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 оны 4 дүгээр улиралд 5.8 хувиар өслөө.
- Засгийн газрын хэрэглээний зардал 2023 оны 4 дүгээр улиралд 6.8 хувиар өссөн байна.
- ОХУ-ын цэргийн армийн зардлын өсөлттэй холбоотой төсвийн зардал тэлэлт, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой эдийн засаг 2021 оны 4 дүгээр улирлаас хойш хамгийн өндөр өсөлт хүрээд байна.

- Экспорт 2023 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеийнхээс 27.0 хувиар, 2021 оны 4 дүгээр улирлын дүнгээс 31.8 хувиар тус тус буурсан байна.
- Импорт 2023 оны 4 дүгээр улиралд өнгөрсөн оны мөн үеэс 5.0 хувиар буурсан байна.
- Экспортын бууралтад тус улсын газрын тос, байгалийн хий, газрын тосны бүтээгдэхүүний үнийн бууралт, биет хэмжээний бууралт гол нөлөө үзүүлсэн байна.

- Инфляцын түвшин 2024 оны 2 дугаар сард 7.7 хувь болж, өмнөх сараас 0.3 нэгж хувиар өссөн байна.
- 2023 оны 12 дугаар сараас хойш инфляцын түвшин аажмаар нэмэгдсээр байгаа нь Төв банкны зорилтот түвшин 4 хувийг давсан хэвээр байна.

- Аж үйлдвэрийн салбарын PMI индекс 2024 оны 2 дугаар сард 54.7 болж, сүүлийн 7 жилийн хугацаанд хамгийн өндөр тэлсэн байна.
- Шинэ захиалгын хэмжээ огцом нэмэгдсэн нь ажил эрхлэлтийг дэмжиж, бараа материалын худалдан авалтыг нэмэгдүүлснээр бодит үйлдвэрлэл өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.
- Бодит үйлдвэрлэлийн өсөлт 2024 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар өссөн нь сүүлийн 3 сарын хамгийн өндөр үзүүлэлтэд хүрээд байна.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ